

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/30

Даланзадгад сум

┌ Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн удирдлагын багийн хурлаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байгууллагуудын тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай), Хяналт шалгалтын хэлтэс (Б.Оюунсүрэн) нарт тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501186

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн
А/30 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгасан эрүүл мэндийн байгууллага

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1	Булган сумын Эрүүл мэндийн төв ЭУ-04/14/05	9048901	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	2030 оны 05 сарын 25-ны өдөр хүртэл	Булган сум, Булган баг
2	Гурвантэс сумын Эрүүл мэндийн төв ЭУ-04/14/06	9048375	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	2030 оны 05 сарын 31-ны өдөр хүртэл	Гурвантэс сум, 4-р баг, Урт 0 тоот
3	Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төв ЭУ-04/14/08	9051015	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	2030 оны 06 сарын 13-ны өдөр хүртэл	Мандал-Овоо сум, Өтгөн багт
4	Номгон сумын Эрүүл мэндийн төв ЭУ-04/14/09	9047808	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	2030 оны 05 сарын 25-ны өдөр хүртэл	Мандал-Овоо сум, Өтгөн багт
5	Цогт-Овоо сумын Эрүүл мэндийн төв ЭУ-04/14/15	9048383	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ	2030 оны 05 сарын 25-ны өдөр хүртэл	Цогт-Овоо сум, 1-р баг, Замын шанд